

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны
..... тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

2024.12.02

Улаанбаатар хот

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ
Монгол Улсын хууль					
1	3	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай 2003-05-30 дугаар 2003_01	14.1.2. эдийн засгийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвчтэй уялдуулан салбарын бүсчлэл, байршлын бүдүүвчийг тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил, байршлыг зохицуулах;	Засгийн газрын 2023.05.03-ны өдрийн 167 дугаар тогтоолоор орон тооны хязгаар 146 болж батлагдан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023.05.23-ны өдрийн А/176 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтэц өөрчлөлт орсонтой холбоотойгоор Нийслэлийн улсын бүртгэлийн газрын 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 189 хорооны улсын бүртгэлийн үйлчилгээний зохион байгуулалтыг Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон цэгийн зохион байгуулалтад оруулж нийт 28 үйлчилгээний төв болон цэгээр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Улсын бүртгэлийн чанар, шуурхай байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 1 дүгээр давхарт, Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Багануур дүүрэг, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дэргэд, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Төв аймгийн Засаг даргын тамгын газарт байрлах Цахим төвд, улсын бүртгэлийн “Цахим үйлчилгээний 24/7 төв”-г тус тус нээж ашиглалтад оруулаад байна.	100
2	5	ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011-12-23 Дугаар 2015-10	14.2.11. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор байгууллагын хэмжээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:	100

			зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах	-УБЕГ-ын төсөвт төвлөрүүлэх орлогоор 45,0 тэрбум төгрөгийн төлөвлөгөөнөөс 2024.11.25-ны өдрийн байдлаар 36.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөө 80 хувийн биелэлтэй байна. -Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 147 мэдээллийг үнэн зөв гаргаж тогтоосон хугацаанд шилэн дансны цахим хуудас болон төвлөрүүлэн захирагчийн цахим хуудсанд сар бүрийн 05-ны дотор бүрэн байршуулан ажилласан. Улсын бүртгэлийн байгууллагын 23 нэгжийн 2023 оны санхүүгийн тайлангийн үйл ажиллагаанд төрийн аудитын байгууллагын дүгнэлтээр 22 нэгж “өөрчлөлтгүй”, 1 нэгж “хязгаарлалттай” дүгнэлт авсан ба 15 нэгж ямар нэгэн алдаа, зөрчилгүй, 8 нэгж 6 акт, 9 албан шаардлага, 12 зөвлөмж бүхий нийт 38 алдаа зөрчил илэрсэн. Дээрх 8 нэгж нь төрийн аудитын байгууллагын нэгдсэн цахим сан болох fas.audit.mn-д мэдээллийг нотлох, дэмжигдэх баримтын хамт 100 хувь хугацаанд нь байршуулсан. Төрийн аудитын байгууллага биелэлтийн үнэлгээг тооцон ажиллаж байна. Зөвлөмжийн биелэлтийн хугацааг мөрдөн ажиллах зөвлөмжийг дээрх 8 нэгжид 05 дугаар сарын 08-ны өдөр 7/6187 тоот бичгээр, мөн дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг 21 аймгийн улсын бүртгэлийн хэлтэст 04 дүгээр сарын 23-ны өдөр 7/5342 албан бичгээр, 2024 оны 03-р улирлын байдлаарх хэрэгжилтийн мэдээг 2024.08.23-ны өдрийн 1/10384 тоот албан бичгээр ХЗДХЯ-ны ХШҮДАГ-т тус тус хүргүүлсэн. Жилийн эцсийн тайлан мэдээг ХЗДХЯ-наас ирүүлсэн хугацааны дагуу 12 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
7	12	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай /Шинэчилсэн найруулга/	10.9.. Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Засгийн газар батална.	“Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022.10.04-ний өдрийн А/277 дугаар тушаалаар “Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам”-ын төсөл боловсруулах	100

		2018-06-21 Дугаар 2018.11.01		үүрэг бүхий Ажлын хэсэгт УБЕГ-ын дарга Д.Дэлгэрсайхан, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд, Эрх зүйн хэлтсийн дарга Б.Хэрлэнчимэг нар ажиллаж байна. Журмын төсөлд төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн эзэмших, ашиглах эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг дундын мэдээллийн сангаар дамжуулан цахимаар бүртгэхээр зохицуулсан. Дундын мэдээллийн сангаар дамжуулан цахимаар бүртгэх боломжтой эсэх, төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээллийн системийн нөхцөл байдал, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн тоон мэдээлэл, тооллогын мэдээллийн бүтцийн талаар холбогдох мэдээлэл ирүүлж, хамтарч ажиллах тухай 2023.10.27-ны өдрийн 1/9966 дугаар албан бичгийг ТӨБЗГ-т хүргүүлээд байна. Өнөөдрийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээллийн систем хөгжүүлэх ажил хийгдэж байна. Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж нэмж оруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн бөгөөд 2024.05.08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн. Хуулийн төсөл батлагдсанаар зөвхөн төрийн гэлтгүй орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам батлагдах эрх зүйн орчин бүрдэх ач холбогдолтой юм. <i>/Батлагдаагүй байгаа/</i>	
8	13	Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ 2019-03-27 Дугаар 2023_10	18.18.6. 18.18.6.ЭНЭ хуулийн 18.15-д заасныг болон автоматаар мэдээлэл харилцан солилцохтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн журам.	Татварын байгууллага улсын бүртгэлийн мэдээллийн санг төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Монгол Улсын Их хурлын 2024.06.05-ны өдрийн 62 дугаар тогтоолын 9 дэх хэсэгт “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, тусгай	100

				зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч өөрчлөгдөхөд төлөх татвар ногдуулах суурийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох” үүрэг даалгаврыг Татварын байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тогтоосон.	
11	21	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.6.19. хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.19, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.2.3-т заасны дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг opendata.burtgel.gov.mn сайтаар нээлттэй байршуулсан. 2024.11.25-ны өдрийн байдлаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийг www.opendata.burtgel.gov.mn цахим хуудсаар хэвийн төлөвтэй 246,400, татан буугдсан 16,144, улсын бүртгэлээс хасагдсан 33,366 хуулийн этгээдийн мэдээллийг тус тус нээлттэй байдлаар харуулж байна.	100
20	40	Улс төрийн намын тухай 2023-07-07 Дугаар 2023.07.07	14.11. Улсын дээд шүүх намыг бүртгэхтэй холбоотой журмыг сонгуулийн төв байгууллага, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн батална.	Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар батлагдаж 2024.01.01-ний өдрөөс дагаж мөрдсөнтэй холбоотой Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024.02.23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
Ерөнхийлөгчийн зарлиг					
59	162	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжилтийг хангах зорилгоор улсын бүртгэлийн байгууллагын газар, хэлтсүүдэд төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангах талаар 2024.03.26-ны өдрийн 7/3868 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлэв. Энэхүү ажлын хүрээнд улсын бүртгэлийн байгууллагын хэмжээнд 2024 онд нийт 3,693 мод тарьж ургуулан, улсын нэгдсэн санд 3,196 мод бүртгүүлээд байна.	100
Засгийн газрын тогтоол					
69	184	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх	3. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус	Гадаадын хөрөнгө оруулагчдаас тус газарт Засгийн газрын иргэд, олон нийттэй харьцах 11-11 төвд 2024	100

		талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_413	хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	оны 09 дүгээр сарын байдлаар өргөдөл, гомдол ирээгүй. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 21.6-д ажлын 10 өдрийн дотор бүртгэнэ гэж заасан байдаг. Иймд тухайн заалтыг ажлын 5 өдөр байхаар, улсын тэмдэгтийн хураамжийг багасгаж дотоодын хуулийн этгээдтэй адил болгож өөрчлөх санал гаргаж, Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/17 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсэгт хүргүүлсэн. Гадаадын иргэн харьяатын газрын гадаад иргэний “Г” регистрийн дугаарыг авч үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор “Үндсэн систем /ХУР/-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ” ЦХХХЯ-ны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай 2024.03.20-ны өдөр байгуулж, ГИХГ-т 2024.06.17-ны өдрийн Н/57 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Гадаадын хөрөнгө оруулагчдын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, хэрэгжилтийг сар бүр Эдийн засаг, хөгжлийн яамны холбогдох албан тушаалтанд цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.	
78	198	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49	Х-3.3. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах.	Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/17 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсэгт ЭЗХ-ийн дарга Б.Хэрлэнчимэг гишүүнээр томилогдон ажилласан бөгөөд ажлын хэсгийн 2 удаагийн хуралд ХЭУБГ-ын улсын ахлах бүртгэгч Б.Лхагвасүрэн нар оролцож гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд хугацааг багасгах, тэмдэгтийн хураамжийн хэмжээг бууруулах зэрэг санал боловсруулан хүргүүлж, хуулийн төсөлд тусгуулсан. <i>(Хууль өргөн мэдүүлснээс хойш Ажлын хэсэг дахин хуралдаагүй)</i>	100

				2024.11.25-ны өдрийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 9,103 компанийн нээлттэй мэдээллийг www.opendata.burtgel.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	
80	205	Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах тухай 2023-02-08 Дугаар 2023_69	4.. "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийг улсын бүртгэлд бүртгүүлж, компанийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2023.02.08-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц үйлдвэрлэх, бичилт хийх "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлагдсан."Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 51 хувийн хувьцаа эзэмшигчээр, "Мигасон" ХХК нь 49 хувийн хувьцаа эзэмшигчээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023.04.11-ны өдөр "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК бүртгэгдсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024.05.16-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй 43 нэр төрлийн 16,115.1 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК-ийн төрийн мэдлийн 51 хувьд тооцон хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/-д шилжүүлсэн тогтоолын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024.07.19-ний өдрийн А/123 дугаар тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, программ хангамж, улсын бүртгэлийн сүлжээг "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК-ийн тусгай зориулалт бүхий байранд нүүлгэн шилжүүлэх, тоног төхөөрөмжийг суурилуулах, программ хангамжийн тохиргоо, интернэтийн сүлжээ, аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2024.11.25-ны өдрийн байдлаар "Хэвлэх үйлдвэр"-т шинэ бэлдцээр хэвлэгдсэн нийт 811,216 паспортоос	100

				энгийн гадаад паспорт 152,264 ширхэг, цахим гадаад паспорт 658,952 ширхэг байна.	
81	206	Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам шинэчлэн батлах тухай 2023-02-08 Дугаар 2023_71	2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2023.02.08-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор “Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг шинэчлэн батлуулсан. УБЕГ-ын даргын 2023.01.04-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар “энгийн гадаад паспорт /цахим/-ыг нэвтрүүлж, олгох ажлыг 2023.03.01-ний өдрөөс эхлүүлэх болсонтой холбоотойгоор бэлтгэл ажлыг хангах, эхлүүлэх, жигдрүүлэх, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан “Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг улсын бүртгэлийн байгууллагын нийт албан хаагчдад танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100
119	255	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2024-01-31 Дугаар 2024_45	3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн мэдээллийг боловсруулж, бүртгэлийг цахимжуулан, мэдээллийг шуурхай солилцож ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (М.Энхсайхан) нарт тус тус даалгасугай.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээллийг “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай мэдээлэл солилцож ажиллаж байна.	100
120	256	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2024-01-31 Дугаар 2024_46	3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2022, 2023 оны хувьцааны ногдол ашиг хүртэх иргэдийн талаарх доор дурдсан мэдээллийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д шуурхай гарган хүргүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (З.Энхболд), Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул), “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ (Т.Батбилэг)-т тус тус үүрэг болгосугай: 3.1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сангаас хувьцаа эзэмших иргэдийн бүртгэлийн мэдээллийн жагсаалт; 3.2.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн үнэн зөв байдлыг ханган ажиллахад Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сангаас хувьцаа эзэмших иргэдийн бүртгэлийн мэдээллийн жагсаалтыг 2022.04.25-ны өдрөөс 2023.04.21-ний өдрийн байдлаар “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ын хүсэлтийн дагуу хүргүүлж ажилласан. Үүнд Монгол Улсын шинээр төрсөн, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан, нас барсан, иргэний харьяатаас гарсан, овог, нэр, регистрийн дугаар өөрчлөгдсөн бүртгэлийн мэдээлэл багтсан болно.	100

			Халамжийн нэгдсэн систем дэх 18 хүртэлх насны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, тэдгээрийн арилжааны банкин дахь баталгаажсан дансны жагсаалт; 3.3. Цахим төлбөрийн баримтын нэгдсэн систем дэх татварын буцаан олголтын төлбөр хүлээн авдаг иргэдийн арилжааны банкин дахь баталгаажсан дансны жагсаалт.	Мөн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ын 2023.10.31-ний өдрийн ирүүлсэн албан бичгийн дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд төлөвийн болон иргэний бүртгэлийн дугаарын мэдээллийг шалган 2023.12.04-ний өдөр хүргүүлсэн бөгөөд 2024.01.25-ны өдөр ирүүлсэн мэдээлэлтэй дахин тулган шалгаж, шинэчлэн хүргүүлэв.	
215	3	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	3.Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний “Хурдан” цэг болон киоск машинаар дамжуулан олгох боломжийг судалж, зохих арга хэмжээ авахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (П.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай.	Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу 2024.10.31-ний өдрийн байдлаар Монгол Улсын 16 нас хүрсэн тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргасан 1,439,716 иргэнд тоон гарын үсэг олгосон. Үүнээс гар утсаар 566,659, иргэний үнэмлэхэд 873,057 /Киоск машинаар 106,836/ Тоон гарын үсгийг улсын бүртгэлийн 104 киоск машин, бусад байгууллагын 1361 ширхэг (Гэрээ системс ХХК 489, Голомт банк АТМ-аар 330, Хаан банкны АТМ-аар 442, ТУЦ-100) цахим /киоск/ машинаар тус тус олгодог болсон.	100
			Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ын техникийн нөхцөл, шаардлагыг хангаж, “DocX” системд холбогдох заавар, аргачлал мөн (http://docx.gov.mn) цахим хуудасны “Байгууллага бүртгүүлэх заавар” цэсийн дагуу байгууллагын (http://edoc.mojha.gov.mn) системийн админ бүртгүүлж, холбогдсон. ЦХИХХЯ, И-Монгол академиас 2024.09.12-ны өдөр зохион байгуулсан “DocX” албан бичиг солилцооны дундын системийн талаарх цахим сургалтад УБЕГ-ын газар, хэлтсийн бичиг хэргийн эрхлэгч нар бүрэн хамрагдсан. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын	100

				систем (Docx)-ийг ашиглаж байх талаар чиглэл хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
157	301	2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл 2022-10-19 Дугаар 2022_50	XII.3.2. Хилээр нэвтэрсэн болон улсын бүртгэл, нийгмийн даатгал, татварын байгууллагад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох талаар зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар "Үндэсний системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглах үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам" батлагдсан. Энэхүү журамд суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас үндсэн болон дэмжих системд мэдээлэл нийлүүлэх, үндсэн болон дэмжих системээр дамжуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд үйлчилгээ авах, хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар мэдээлэл солилцох үндсэн систем нь "Хур" систем юм. "Хур" системийн гэрээг ЦХХХЯ хариуцан төрийн байгууллагуудтай хийж байна. ТатЕГ, НДЕГ зэрэг төрийн байгууллагууд тус яамтай гэрээ байгуулан улсын бүртгэлийн мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Улсын бүртгэлийн асуудлаар төрийн болон бусад байгууллагатай мэдээлэл солилцох ХҮР систем болон дундын мэдээллийн сангийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021.10.07-ны өдрийн 153 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн анхдугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд "Нийгмийн даатгалын ерөнхий газар", "Татварын ерөнхий газар"-т 2020, 2021 онуудад бүртгэсэн 173 гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн жагааслыг гарган хүргүүлж, нийгмийн даатгал, татвар төлөлтийн талаарх мэдээллийг авч холбогдох хяналтыг тавьж, хамтран ажиллаж байна.	100
175	339	2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19	ХҮИИ.8.3. Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод тухай бүр аюулгүй байдлын хангах талаар дэмжлэг, тусалцаа үзүүлж ажилладаг болно. Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар төмөр замын боомтын төрийн нэг цэгийн үйлчилгээний цогцолбор	100

			Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт.	ашиглалтад орж, хилийн хяналтын байгууллагууд 2023.08.01-ний өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Хилийн чанадад ажиллаж байгаа 45 Элчин сайдын яам, Консулын газрын бүртгэлийн ажилтанд иргэний улсын бүртгэлийн онлайн сүлжээнд бүртгэл хөтлөх, лавлагаа олгох, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын мэдээлэл удирдах, тоон гарын үсэг олгох программыг танилцуулж, программд ажиллах дадлага ажил хийлгэж газар дээр нь мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.	
193	391	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49	XVI.2.1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс хойш 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд шинээр төрсөн, Монгол Улсын харьяатад орсон иргэн бүрд үнэ төлбөргүйгээр нэмж эзэмшүүлэх, өмнө нь 1072 хувьцааныхаа зарим хэсгийг, эсхүл бүхэлд нь худалдсан, суутган тооцуулсан Монгол Улсын иргэдэд худалдсан, суутган тооцуулсан хувьцаагаа нэрлэсэн үнээр нь буцаан худалдах боломж олгох, цаашид нас барсан иргэдийг хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасах, шинэ төрсөн Монгол Улсын иргэнд хувьцаа эзэмшүүлэх зэрэг асуудлыг судлан холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт даалгав.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг 2012.04.12-ны өдрөөс хойш 2023.12.31-ний өдрийг дуусталх хугацаанд шинээр төрсөн, Монгол Улсын харьяатад орсон иргэн бүрд нэмж эзэмшүүлэх, нас барсан иргэдийг хасах арга хэмжээний хүрээнд мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалган, шинэчилсэн мэдээллийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д хүргүүлэн ажилласан. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээллийг “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай мэдээлэл солилцож ажиллаж байна.	100
201	402	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг, дарга нарт	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д Улсын бүртгэлийн ерөнхий газар нь чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх, Хүний нөөцийн талаарх, Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх, Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх, бусад мэдээллийн хүрээнд нийт 113 мэдээллийн нээлттэй	98

				байдал 2024.11.25-ны өдрийн байдлаар 98 хувьтай байна.	
				99.8%	
				4.9	